

НИЙСЛЭЛИЙН ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙН ГАЗАР

ИЛТГЭХ ХУУДАС

/БНСУ-ын Сөүл, Гвангянг хотуудад томилолтоор ажиллаж, олон улсын туршлагыг судалсан ажлын талаар/

2015 оны 11 дүгээр сарын 20

Улаанбаатар хот

Нийслэл Улаанбаатар хотод Монгол Улсын нийт хүн амын 45.9% буюу 1 314 486 хүн амьдарч байгаагаас 32,2% буюу 424 411 нь 0-18 насны хүүхэд байгаагаас 2013 онд 5793, 2014 онд 12505, 2015 онд 15877 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байна. Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газраас эдгээр хүүхдүүдийн сан сайхны төлөө

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд гэрээр хөгжлийн үйлчилгээ үзүүлэх хөтөлбөр
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих нийслэлийн хөтөлбөр
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих нь төсөл
- “Хамтын хөгжил” сэдэвт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тэдний өмнө үүрэг хүлээгчдийг чадавхижуулах төслийг боловсруулан олон улсын байгууллага, төрийн бус байгууллагатай хамтран тодорхой ажлыг эхлүүлсэн. Цаашлаад эдгээр төсөл төсөлбөрийн санхүүжилтийг шийдвэрлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжлүүлэх, эрх ашгийг нь хангах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлүүлэх төвийг нийслэлд байгуулахаар зорилт тавин ажиллаж байна.



Тус зорилтынхоо хүрээнд олон улсад тодорхой зорилго, үүрэг бүхий “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэтгэл зүй, сурган, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын тусламж дэмжлэг үзүүлэх” төвийг байгуулж үйл ажиллагаагаатай танилцах, туршлага судлах зорилгоор нийслэлд нэвтрүүлэх зорилгоор Сайн Хөрш олон улсын байгууллагын санхүүжилттэйгээр БНСУ-ын Сөүл хотын

нийгмийн үйлчилгээний сайн дурын ажилтай танилцах, Гванянг хотын захиргаатай хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асрах төвийн үйл ажиллагаатай танилцах, тэдгээр хүүхдүүдтэй ажилладаг мэргэжлийн хүмүүсээс зөвлөгөө, арга зүйн дэмжлэг авах, санал солилцох, олон улсын туршлагыг судлах зорилгоор тус газраас 5 хүний бүрэлдэхүүнтэй баг 2015 оны 11 дүгээр сарын 09-нөөс 13-ны өдрүүдэд томилолтоор ажилласан. Үүнд:

2015 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр БНСУ-ын Гвангянг хотын захиргаатай

1.Хүний нөөцийн солилцоо,

2.Хоёр орны хоорондын залуучуудын соёлын үйл ажиллагаа

3.Бусад арга хэмжээ, уулзалт гэсэн 3 чиглэлийн хүрээнд хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурав.



Хүүхэд, залуучуудын өдөр өнжүүлэх төв



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асрах төв



Сөүл хотын сайн дурын төв



ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН П.ОЮУН

ХЯНАСАН:
ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА С.БАТСҮХ